

Монголын үнэт цаасны биржид гишүүнээр элсэх хүсэлт гаргагч нь Гишүүнчлэлийн журмын 3.7-3.19 заасан материалуудыг доор дурьдсан дарааллын дагуу бүрдүүлж өгнө. Гишүүнчлэлтэй холбоотой бүхий л үйл ажиллагаа **member.msx.mn** сайтаар дамжин явна.

**1. Дараах бүрдүүлэх материалуудыг ажлын 2 хоног дотор бүрдүүлж онлайн эрхээрээ (member.msx.mn) Биржид илгээнэ.**

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2. Улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар, дүрэмд оруулсан боловч улсын бүртгэлд бүртгэгдээгүй байгаа нэмэлт өөрчлөлт
3. СЗХ-ны тусгай зөвшөөрлийн хуулбар, хавсралт
4. Гүйцэтгэх удирдлага болон Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх бүхий ажилтны үнэмлэхийн хуулбар, анкет (Гишүүнчлэлийн журмын маягт 3-ын дагуу), өмнө ажиллаж байсан байгууллагын эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий тодорхойлолт (МЗ Маягт)
5. Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан
6. Компанийн үйл ажиллагааг зохицуулсан дотоод журам, харилцагчтай байгуулах гэрээний төсөл
7. Арилжаанд оролцох эрх авах эсвэл авсан ажилтны хувьд нууцлалын гэрээ байгуулсан талаарх тухайн ажилтны гарын үсэг бүхий албан бичиг
8. Хувь нийлүүлэгч болон толгой, охин компанийн тухай мэдээлэл, энэхүү холбоо хамаарлыг нотлох баримтуудын хуулбар
9. Компанийн болон давуу эрхийн хувьцааны 5 (тав)-аас дээш хувийг эзэмшигч этгээдийн анкет (Гишүүнчлэлийн журмын маягт 2-ын дагуу)
10. Шаардлагатай гэж үзвэл Гишүүнчлэлийн журмын 2.8-д заасан гэрээний хуулбар

**2. Дараах бүрдүүлэх материалуудыг ажлын 2 хоног дотор бүрдүүлж эх хувийг Биржид хүргүүлнэ. Дээрх материалуудыг өөрийн биеэр Биржийн байранд авчирч, гишүүнчлэлийн мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.**

1. Гишүүнээр элсэх хүсэлт гаргагчийн өргөдөл (маягт 1)
2. Санхүүгийн баримт бичиг дээр гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар

**3. Шийдвэр гаргаж, мэдэгдэнэ.**

1. Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгжнээс ТУЗ-н хуралд бэлтгэнэ.
2. Материал бүрдсэнээс хойш 10 хоногийн дотор ТУЗ-ийн шийдвэр гаргана.
3. Шийдвэр гарсанаас хойш 3 хоногт багтаан гэрээ байгуулна.
4. Клирингийн ерөнхий гишүүнтэй гэрээ байгуулна.

**Хаяг:**

703 тоот, GB Плаза, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

**Цахим шуудан:**

[Info@msx.mn](mailto:Info@msx.mn), [gantulga@msx.mn](mailto:gantulga@msx.mn)

**Утас:**

70000501, 70000502

**Цахим хаяг:**

[www.msx.mn](http://www.msx.mn)